

Хүүхдэд зориулсан Библи  
танилцуулж байна

Бурхан боол Иосефийг  
өргөмжилсөн нь



**Зохиогч: Edward Hughes**

**Зураглаач: M. Maillot; Lazarus**

**Найруулсан: M. Maillot; Sarah S.**

**Орчуулсан: Damdin Norolsuren**


**Бүтээсэн: Bible for Children**  
**[www.M1914.org](http://www.M1914.org)**

**©2014 Bible for Children, Inc.**

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах  
эрхтэй харин худалдахыг хориглоно.**




Иосеф гэм буруугүй  
байсан ч эзэн  
Потифар түүнийг  
шоронд хориулжээ.  
Шоронд  
Иосеф  
дуулгавартай  
бас бусдад  
тусалж  
байлаа.



Шоронгийн  
харгалзагч Иосефт  
итгэж бүх хоригдлыг  
түүнд даатгав.

Бурхан  
Иосефтэй  
хамт байж  
түүний  
үйсийг  
ерөөв.



**Хааны сөнч талхчин  
хоёр тэр шоронд  
байлаа.**



Нэгэн өдөр  
"Яагаад та нар  
ихэд гуниглана  
вэ?"



гэж Иосеф  
тэднээс асуув.



**Тэд "Бидний  
зүүдийг тайлах хүн  
алга" хэмээн хэлжээ.**



**Иосеф "Бурхан  
чадах болно!" гэв.  
"Надад зүүдээ яриач"  
гэв.**





Иосеф сөнчид хандан "Таны зүүдний  
утга нь та гурван өдрийн дараа хаан  
Фараоны  
дэргэд буцан  
очиж түүнд  
үйлчлэх  
болно"  
ГЭВ.



"Эндээс гараад намайг  
дурсаарай хаан Фараонд

намайг  
чөлөөлж  
өгөөч гэж  
дамжуулаарай"  
ГЭВ.




Харин талхчинд "Та гурван өдрийн  
дараа үхэх болно" гэв.

Хоёр  
зүүд  
биелсэн  
юм.



Гэвч сөнч шоронгоос  
гараад хаан Фараон  
тавгүй зүүд  
зүүдлэх




хүртэл  
Иосефийг  
мартжээ.




Нэгэн өдөр хаан "Би зүүд  
зүүдэллээ" гэв.


Түүний  
зүүдийг  
ямар ч



МЭРГЭН  
ХҮМҮҮС ТАЙЛЖ  
ЧАДСАНГҮЙ.



Тэр үед сөнч  
Иосефийг  
санав.



Тэр түүний тухай  
Фараонд хэлэв.



**Фараон Иосефруу хүн  
илгээв. "Таны зүүд бол  
Бурханы сануулга юм" гэж  
Иосеф хаанд хэлэв.**




**"Египет орон даяар долоон  
сайхан ургац арвин өнтэй жил  
болно, түүний араас долоон жил ган  
өлсгөлөн болно" гэв.**





**"Ургац арвин өнтэй  
долоон жилд хүнс  
буудайгаа сайн  
нөөцлөх  
хэрэгтэй" ...**



**... гэж Иосеф  
Фараонд зөвлөөд  
"эс тэгвэл  
ард түмэн  
өлсгөлөнгөөс  
болж үхэх  
аюулд  
орно" гэв.**



**Фараон  
"Бурхан  
чамтай хамт  
байгааг би  
харлаа" ...**



**... гээд "Чи  
Египетийг захирах  
болно миний  
дараа хоёр  
дахь эрх  
мэдэлтэй  
хүн чи  
боллоо"  
хэмээн  
зарлав.**



**ӨНТЭЙ ДОЛООН ЖИЛ БОЛОВ. ТҮҮНИЙ  
АРААС ГАНТАЙ ДОЛООН ЖИЛ БОЛОВ.**



Ургацаа арвин ихээр нөөцөлсөн  
Египетээс бусад газар хоол хүнс  
хомсдов. Иосефийн төрсөн нутагт  
Иаковын гэрийнхэн ч



ӨЛСГӨЛӨНД АВТАВ.



**Олон орноос ирсэн хүмүүс Египетруу**

**хоол хүнс худалдан**

**авахаар**

**явцгаав.**



**Иаков хөвгүүддээ "Та нар ч бас яв"**

**"үгүй бол бид бүгд**

**өлсөж үхэх**

**болно"**

**ГЭВ.**






**ХӨВГҮҮД НЬ ХООЛ ХҮНС ХУДАЛДАН  
АВАХААР ЕГИПЕТЭД  
ИРЭВ.**



**Иаковын хөвгүүд  
Египетийн захирагч хүндэт  
хүний өмнө өвдөг сөгдөн  
мөргөв. Тэд өөрсдийн дүү  
Иосефийг таньсангүй.**



**Харин Иосеф тэднийг таньж байв.  
Иосеф хүүхэд байхдаа зүүдэлж  
байснаа санав. Бурхан  
түүнийг ах дүү нараас нь  
дээгүүр өргөмжилжээ.**



Иосеф мэргэн ухаантай  
нэгэн байв. Тэр тэдэнтэй  
ширүүн ярьж ах  
Симеоныг  
барьцаанд  
авав.



"Хоол хүнс аваад гэртээ  
очоод бага дүүгээ дагуулан  
буцаж ирцгээ  
ХЭМЭЭН"  
ТЭДЭНД

тушаав.



Ах нар нь олон жилийн  
өмнө дүү Иосефоо  
худалдсанаас болж  
Бурхан ...



**... биднийг ийнхүү  
шийтгэж байна  
хэмээн боджээ.**



**Иаков болон хөвгүүд  
нь юу болоод байгаад  
гайхаж байв.**





**"Худалдаж авсан буудайтай хамт  
бидний мөнгийг хамт хийжээ.**

**Захирагч бидэнд бага  
дүү Бениаминийг авч**

**ирээрэй гэсэн"**

**ГЭВ.**



**Иаков Бениаминийг явуулсангүй.  
Гэвч удалгүй хүнс дуусав.  
Ах нар нь Египетруу  
явах болж Бениаминийг  
авч явлаа.**



**Иосеф Бениаминийг хараад зарцдаа  
найрын ширээ бэлтгэ гэж тушаав.**

**Тэр ах дүү нараа найрт урив. Иосеф**

**"Та нарын эцэг амьд уу тэр сайн**

**сууж байгаа юу?"**

**гэж асуув.**



**Магадгүй тэр энэ үед бүх гэр бүлээ  
хэрхэн авч ирэх тухай бодож байсан  
байх.**



Иосеф түүний ах нар  
олон жилийн өмнө  
хийсэн хэрэгтээ  
үнэхээр гэмшиж  
байгаа эсэхийг

мэдэхийг  
хүсжээ.



Найрын дараа тэр та  
нар манайхаас юм  
хулгайлсан байна  
гээд "Та нарыг  
шийтгэхийн

тулд Бениамин  
дүү чинь миний  
боол болж энд  
үлдэх болно" гэв.



Эзэн минь оронд нь  
миний амийг ав  
гэж Иуда гуйв.  
Иосеф өөрийг нь  
худалдаж байсан

ах Иуда нь ихэд  
өөрчлөгдсөнийг  
харав.



**Иосеф гэр бүлээ гэсэн  
хайраа нууж  
чадсангүй  
тэр бүх  
Египет  
үйлчлэгч**

**нараа  
гадагш  
явуулав.**





**Тэгээд тэр уйлж эхлэв.**

**"Би та нарын**

**Египетруу**

**худалдсан**

**Иосеф дүү**

**чинь**

**байна"**


**ГЭВ.**



**Ах нар нь мэл  
гайхаж бас  
айж юу ч  
хэлэхээ  
мэдэхгүй  
байлаа.**




**Иосеф  
ах нараа  
урамшуулав.**




"Та бүхнийг

ӨЛСГӨЛӨНГӨӨС  
АВРАХЫН ТУЛД ...



... Бурхан намайг


Египетийн  
захирагч  
болгожээ.



# Яваад Эцгийг минь

авч ир.


Би та бүхнийг  
хамгаалах  
болно" гэв.



# Иаков Иосеф дээр

ирж бүх гэр  
бүлээрээ Египетэд  
амар тайван  
амьдран суух

**БОЛОВ.**



Бурхан боол Иосефийг өргөмжилсөн нь

Бурханы үг Библиээс авсан түүх

Эхлэл 39-45

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130





**Төгсөв**



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



**Хэрвээ та энэ үнэнд итгэж  
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:  
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон  
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та  
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж  
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос  
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр  
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд  
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө  
амьдрахад туслаач. Амен.**

**Библи уншиж өдөр бүр Бурхантай  
ярилцаарай! Иохан 3:16**

